



92  
Бүгд Найрамдах Монгол Ард Улсын

Сайд нарын Зөвлөлийн

## ТОГТООЛ

1964 оны II дүгээр  
сарын 5-ны өдөр

Дугаар 488

Улаанбаатар  
10Т

Барилгын техникийн баримт бич-  
гийн архив байгуулах тухай

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын архитектурын газарт орон тоонд нь багтсан барилгын техникийн баримт бичгийн архив байгуулахыг Улаанбаатар хотын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа /н.ЛУВСАНЧОЙМБОЛ/-д зөвшөөрсүгэй.

2. Барилгын техникийн баримт бичгийн архивт: Улаанбаатар хотын дотор баригдсан нийгэм ахуйн барилга байгууламж, тохижуулалт, ус түгээгүүр, ариутгах татуурга, дулаан, цахилгаан, зам гүүр, талбай, радио, телефоны шугам сүлжээ, топогеодезийн зураг, хөрсний ус, газар хөдлөлт, газар зүйн хайгуул зэрэг инженер хайгуулын ажлын материалыг гүйцэтгэлийн нь актуудын хамт хадгалуулж байсугай.

3. Хотын архитектурын газрын барилгын техникийн баримт бичгийн архивт 1955 оноос хойш Улаанбаатар хотын дотор баригдсан нийгэм ахуйн барилга байгууламж, хайгуулын ажлын материал I хувийг энэ онд, цаашид баригдах мөн барилга байгууламж, хайгуулын ажлын зураг төсвийг цаг тухайд нь шилжүүлэн өгч байхыг холбогдох яам, газруудын сайд, дарга нарт даалгасугай.

Б Н М А Улсын Сайд нарын  
Зөвлөлийн I-р орлогч дарга

ЮЛОМЖАМЕ

Б Н М А Улсын Сайд нарын  
Зөвлөлийн Хэрэг эрхлэх  
газрын дарга

БАДАРЧ

Хуулбар үнэн: Тогтоол ангийн  
эрхлэгч

ДАГВАДОРЖ